

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.07.01-07.05

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтаж буй үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

“Их-20” уулзалтын дараа АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй түр хугацаанд зөвшилцөлд хүрсэн талаар мэдээлж, АНУ худалдааны дайнд “яллаа” хэмээн зарлав. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн индексүүд өсжээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч байгаа хэдий ч АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ бууруулж, мөнгөний бодлогоо зөөллөх талаар дохио өгсөнтэй холбоотойгоор зах зээлд эерэг хүлээлт бий болоод байгаа аж.

Энэ долоо хоногт АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлснээр тус улсын хөдөлмөрийн хөлсний хэмжээ урьдчилан таамагласан түвшинг давлаа.

Дэлхийн нефтийн салбарт тэргүүлэгч “Weatherford International” компани 7-р сарын 1-ний өдөр дампуурлаа зарласан байна. Ингэснээр 2014 оноос хойш анх удаа эрчим хүчний салбарын томоохон компани дампуурч байгаа ажээ.

АНУ-ын жижиглэн худалдааны компаниуд Amazon, Google-ын мөрдөн байцаалтад туслахын тулд монополын эсрэг зарга үүсгэхээр төлөвлөжээ.

Европ: Европын төв банк бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогыг зөөлрүүлэх талаар мэдээлж, Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Мөн Европын төв банкны дараагийн тэргүүнээр ОУВС-гийн захирал хатагтай Кристин Лагард нэр дэвших болсонтой холбоотойгоор хөрөнгийн зах зээлд эерэг хүлээлт бий болсон байна. Тус байгууллагын одоогийн тэргүүн ноён Марио Драгги 10-р сард албан үүргээ хүлээлгэн өгөх үед хатагтай Кристин Лагард мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн зөөлрүүлнэ хэмээн мэдэгджээ.

ХБНГУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд муудсаар байна. Эрэлт унаснаар 5-р сард тус улсын аж үйлдвэрийн захиалга 2.2 хувиар, гадаад худалдааны экспортын гэрээ 4.3 хувиар тус тус буурчээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2.3 хувиар өсөж хаагдлаа.

Япон улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны мэдээлснээр 5-р сард тус улсын жижиглэнгийн худалдаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар өсжээ.

Япон, Өмнөд Солонгосын маргаан хурцадлаа. Ерөнхий сайд Шинзо Абэгийн тавьсан экспортын хязгаарлалт Пүрэв гарагаас хэрэгжиж эхэлснээр 1910-1945 онд Солонгосын хойгийг колоничилж байсан Японы түрэмгийлэгчид зохих ёсоор уучлал гуйх ёстой гэдэг асуудал дахин сөхөгдөв.

Эх сурвалж: Troweprice.com, ZGM.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,723.36	-0.30% ▼
Dow Jones	АНУ	26,922.12	1.21% ▲
S&P 500	АНУ	2,990.41	1.65% ▲
Nasdaq	АНУ	8,161.79	1.94% ▲
S&P/TSX	Канад	16,541.99	0.98% ▲
FTSE 100	Их Британи	7,553.14	1.72% ▲
S&P/ASX 200	Австрали	6,684.90	1.00% ▲
Nikkei 225	Япон	21,764.38	2.30% ▲
Hang Seng	Хонг Конг	28,774.83	0.81% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.23
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.03
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.07
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.19
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.93
DBM' 2023	USD	7.250%	104.64
TDBM' 2020	USD	9.375%	103.76

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.370	-0.03 ▼
Libor 3M	2.310	-0.01 ▼
Libor 6M	2.210	0.01 ▲
Libor 1YR	2.190	0.01 ▲
US 2YR Bond	1.843	0.07 ▲
US 3YR Bond	1.797	0.07 ▲
US 5YR Bond	1.814	0.04 ▲
US 10YR Bond	2.020	0.01 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.07.05	Өөрчлөлт
USD	2,658.59	0.03% ▲
CNY	386.50	0.17% ▲
EUR	2,995.70	0.69% ▲
RUB	41.81	0.07% ▲
KRW	2.27	0.88% ▲
JPY	24.60	-0.16% ▼
CAD	2,034.82	0.74% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,399.45	-0.72% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.00	-2.06% ▼
Зэс	USD/lb.	266.10	-1.93% ▼
Нүүрс	USD/MT	77.12	12.04% ▲
WTI газрын тос	USD/bbl.	57.51	-1.64% ▼
Brent газрын тос	USD/bbl.	64.23	-3.49% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.42	4.76% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. V	11.03%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. V	11.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. V	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. V	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. V	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 54 компанийн 7,951.3 сая төгрөгийн 2,355,707 ширхэг хувьцаа арилжигдав.

“Дархан уул тэжээл” /DAR/ компанийн хувьцаа 51.95%-аар буюу хамгийн ихээр өсөж 1597.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Нийслэл өргөө” /NUR/ компанийн хувьцаа 26.22%-аар буурч 3,700.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


7-р сарын 5-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,593.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,723.36 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.30%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	7,951.4
Зах зээлийн үнэлгээ	2,593,917.4

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,723.36	-0.30% ▼
MSE I индекс	9,694.74	-0.50% ▼
MSE II индекс	8,063.65	-0.65% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
МИК Холдинг	488,750	7,297,037,500
Би Ди Сек	284,595	221,407,890
Таван толгой	16,545	122,097,700
Монгол базальт	183,524	54,516,674
Инвескор ББСБ	24,233	43,741,598

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан уул тэжээл	1,597.00	51.95% ▲
Хүннү менежмент	372.08	32.25% ▲
Баян-Алдар	1,322.00	32.20% ▲
Е-Моние	1,954.00	32.03% ▲
Хүрд	3,236.00	15.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нийслэл өргөө	3,700.00	-26.22% ▼
Бөхөр	2,475.00	-22.66% ▼
Техник импорт	11,980.00	-14.43% ▼
Монголын цахилгаан холбоо	400.00	-11.11% ▼
Дархан хүнс	3,940.00	-8.37% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	14,639,775,510
БиДиСек	544,721,326
Ард секюритиз	109,939,531
Голомт Капитал	89,302,971
Гаули	88,793,156

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	572.42	609,159
Таван толгой	7,390.00	389,196
Говь	14,500.00	300,285
МИК Холдинг	292.00	227,793
Инвескор ББСБ	1,777.00	127,461

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Баялаг-Сүмбэр ХК”-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг танилцууллаа

МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй Баялаг сүмбэр /MSE:BAJ/ компани шинэ хөрөнгө оруулагчтай болсонтой холбоотойгоор зарим нэг өөрчлөлтүүдийг компанидаа хийж эхэллээ.

Тус компани нь 2019 оны 7-р сарын 1-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг танилцуулсан байна. Хурлаар компанийн оноосон нэрийг “Global life technology” болгон өөрчлөх, компанийн дүрэмд өөрчлөлт оруулан шинэчлэн найруулах, компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдсэн байна.

Компанийн нийт хувьцааны 89.6%-ийг БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Хөхөө Агротех” ХХК худалдан аваад байгаа юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын анхааралд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани нь Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.6, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтад заасны дагуу хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны дотор Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй байдаг билээ.

Хэрэв заасан хугацаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн зүгээс зөрчлийн талаар олон нийтэд болон Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, цаашид зөрчил давтагдсан тохиолдолд СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”, МХБ-ийн холбогдох журмууд болон Бүртгэлийн гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг ногдуулахыг анхаарна уу.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Эхний хагас жилийн арилжааны 35%-ийг гадны хөрөнгө оруулагчид хийжээ

2019 оны эхний хагас жил дуусаад байна. Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын зүгээс дотоодын захад гадны хөрөнгө оруулалтыг татах эрмэлзэлтэй байгаа. Үүний хүрээнд эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхээр зорьж байгаа юм.

Тэгвэл эхний хагас жилийн байдлаар Монголын хөрөнгийн зах дээр 90 гаруй тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдснаас 35%-ийг нь гадны хөрөнгө оруулалт эзлэв.

Гэхдээ энэхүү хөрөнгө оруулалт нь зах зээл дээр гарсан IPO-нд стратегийн хөрөнгө оруулалт болон томоохон багцын арилжаа хэлбэрээр захад орж иржээ.

Эх сурвалж: Marketinfo.mn

“Улсын их дэлгүүр” ХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийлээ

Хороо нь “УИД” ХК-тай 2017 онд “УИД ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, бие даасан байдлыг хангуулах гэрээ”-г байгуулж тус гэрээнд “УИД ХК-ийн барилгыг түрээслэх гэрээний үнийн дүнг тухайн үеийн зах зээлийн ханштай дүйцүүлэх...” гэж заасан. Гэвч “УИД” ХК нь “Номин реалтор” ХХК-тай түрээсийн гэрээг зах зээлийн үнээс хэт бага үнээр хийж дээрх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үүний улмаас “УИД” ХК нь 2016 онд 3.9 тэрбум, 2017 онд 2.4 тэрбум, 2018 онд 2.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллах, нэгж хувьцаанд 2016 онд 106 төгрөг, 2017 онд 65 төгрөг, 2018 онд 71 төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах боломжийг тус тус алдсан байна гэж шалгалтын ажлын хэсгээс дүгнэлээ.

Түүнчлэн “УИД” ХК нь “Номин холдинг” ХХК-тай зээлийн гэрээг гадаад валютаар байгуулж, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн тул Санхүүгийн зохицуулах хорооноос Улсын ерөнхий прокурорын газарт хандан зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн ажиллагааг эхлүүлээд байна.

Мөн шалгалтын ажлын хэсгээс “УИД” ХК-ийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бусад үйл ажиллагаанд торгууль оногдуулж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллахаар боллоо.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



МХБ дээр 7.3 тэрбум төгрөгийн багцын арилжаа явагдлаа

2019 оны 7-р сарын 5-ны өдөр “МИК Холдинг” ХК-ийн /MSE:MIK/ багцын арилжаа явагдлаа. Багцын арилжаагаар тус компанийн 488,750 ширхэг хувьцаа 7.3 тэрбум төгрөгөөр арилжигджээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК ХХК

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ноолуурын дундаж үнэ 95 мянган төгрөг байна

ХАА-н түүхий эд, бараа бүтээгдэхүүний биржийн арилжааны мэдээгээр 6-р сарын 29-ны байдлаар боловсруулаагүй бараан ноолуурын үнэ кг нь 99 мянган төгрөг байна.

Дээрх ноолуурын дээд үнэ кг нь 120 мянга, дундаж үнэ 102 мянга, харин доод үнэ нь 95 мянган төгрөг байна.

Эх сурвалж: Montsame.mn

“Эрдэнэс Монгол” хөгжлийн стратегия танилцуулав


“Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын баг мэдээлэл хийж, олон нийтэд хөгжлийн стратегия танилцууллаа. Тус компани дунд хугацааны стратегия баталж, боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын зөв бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү уулзалтын эхэнд онцлов. Тэрбээр “үнэт металл, алт цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, нүүрсний давхаргын метан хийн эрэл хайгуул хийх, олборлох үйлдвэр байгуулах, кокс, ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих зэрэг төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн Засгийн газраас Асгатын мөнгө полиметаллын ордын ашиглалтын дөрвөн тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн бөгөөд одоогоор далд уурхайн чиглэлээр мэргэшсэн инженерүүдээс бүрдсэн багийг Асгатын мөнгө, полиметаллын ордод ажиллуулж, ордын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт өгөх ажлыг хийж гүйцэтгэж байна” гэлээ.

Үүнээс гадна Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэглээний 90 гаруй хувийг хангадаг Багануур, Шивээ-Овоогийн уурхайн хэвийн, найдвартай ажиллагааг хангах хүрээнд технологийн шинэчлэл хийх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж байгааг мэдээлэлдээ дурдсан юм. Монгол Улсын Засгийн газар, Япон улсын хамтын ажиллагааны банкттай хамтран хэрэгжүүлж буй “Экспортын зээлийн шугам нээх тухай төсөл”-ийн хүрээнд тус уурхайнуудын техник, технологийн шинэчлэлийг хийж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр зорьж байгаа аж.

“Эрдэнэс Монгол” ХХК цаашид байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндэсний томоохон хөрөнгө оруулалтын компани болох зорилго тавьжээ. Энэ зорилгыг хангах ажлын хүрээнд дунд хугацааны бизнесийн стратегийг батлан хэрэгжүүлж байгаа аж.

Эх сурвалж: ZGM.mn

БУСАД МЭДЭЭ



Зээлийн хүү өнгөрсөн оныхоос 2.8 хувиар буурчээ

7-р сарын 5-ны өдөр Монголбанкнаас 2019 оны эхний хагас жилд хийсэн ажлаа танилцууллаа.

Юуны өмнө Төвбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлого инфляцийн зорилтыг хангаж эдийн засгийн өсөлтийг дэмжсэн гэдгийг Монголбанкны дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн онцолж байв. Тухайлбал, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого нь инфляцийг Төвбанкны зорилт буюу 8 орчим хувьд тогтворжуулж, үр дүнд эдийн засгийн өсөлт сүүлийн үед тогтмол өсөж, нэгдүгээр улиралд 8.6 хувьд хүрлээ.

Энэ онд “Банк, санхүүгийн салбарын хууль эрхзүйн шинэтгэлийг хөтөлбөр”-ийг үргэлжлүүлжээ. Өнгөрсөн хугацаанд Монголбанкны хуримтлагдсан алдагдал 1.2 их наяд төгрөгөөр буурч, үүнийг аудитаар баталгаажуулсан байна. Гадаад валютын улсын нөөц дөрвөн тэрбум ам.долларт хүрч өсжээ.

Мөн зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлснээр үр дүнд хүрч, шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү энэ оны тавдугаар сард 17 хувьд хүрчээ. Үүнийг өнгөрсөн оны тавдугаар сартай харьцуулахад 2.8 хувиар буурсан байна.

“Эх орныхоо алтыг эрдэнэсийн санд” аяныг явуулсны хүрээнд 209 сая ам.долларын үнэт металл худалдан аваад байгааг Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч О.Эрдэмбилэг нар мэдээллээ. Цаашлаад:

- Мөнгөн дэвсгэртийн хамгаалалтын элементүүдийг сайжруулж, нөөц дахин бүрдүүлэлийг хэрэгжүүлсэн
- Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж байна
- Банкуудын өөрийн хөрөнгөб нэмэгдүүлсэн байдалд хяналтын аудит хийхээр болсон
- Монгол Улс ОУВС-гаас боловсруулан гаргасан статистикийн “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт”-д шилжсэн байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.